# Бие даасан дулааны эх үүсвэр, Уурын зуух

**Тайлбар:** Уурхайд шинээр баригдаж байгаа ажилчдын хотхон, захиргааны барилга болон цаашид өсөн нэмэгдэх дулааны хэрэглээг тооцон төлөвлөсөн бөгөөд түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр уурын зуухны барилга угсралтын ажлыг гүйцэтгэхээр техникийн тодорхойлолтыг боловсруулж Худалдан авах ажиллагааны хэлтэст хүргүүлжсэн.

**Барилга байгууламжийн бүрэлдхүүн хэсэг:**

- Уурын зуухны барилг
- Түлш хадгалах агуулах
- Үнсний зайлуулах талбай
- Цэвэр усны хоолой
- Цахилгаан хангамж
- Дулааны гол шугам хоолойтой холбох дулааны худаг 2ш /барилгаас 5 м зайд/
- Бохир ус зайлуулах шугам хоолой
- Гадна гэрэлтүүлэг,Нүүрсний агуулахын гэрэлтүүлэг
- Хашаа хаалга төлөвлөх



**"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН УУРХАЙД ШИНЭЭР БАРИГДАХ УУРЫН ЗУУХНЫ БАРИЛГА БАРИХ , ХАЛААЛТЫН ТОГОО УГСРАХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

| | |
|---|---|
| 1. Зураг төсөл боловсруулах үндэслэл, зорилго | Уурхайд шинээр баригдах ажилчдын хотхон, уурхайн захиргааны барилгуудын болон цаашид өсөн нэмэгдэх дулааны хэрэглээг тооцон усан халаалтын тогоо суурилуулах уурын зуухны барилга барих,холбогдох инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв боловсруулах |
| 2. Зураг төсөв боловсруулах үндэслэл | "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2020 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө |
| 3. Зориулалт | Шинээр баригдах Ажилчдын хотхон, Уурхайн захиргааны барилгуудыг дулаан болон хэрэгцээний халуун усаар хангах |
| 4. Байршил | Өмнөговь аймаг Цогтцэций сум |
| 5. Хүчин чадал | Халаалтын нийт ачаалал- 0,7 Гкал/ц; Халуун усны нийт ачаалал-0,4 Гкал/ц<br>Нөөц хүчин чадлыг 20 хувиар тооцох |
| 6. Технологийн горимын үндсэн шаардлага | Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай технологи сонгох |
| 7. Ажиллах горим | Халаалтын горимд ажиллах хугацаа 10 дугаар сараас дараа оны 6 дугаар сар<br>Хэрэгцээний халуун ус хангамж - жилийн турш 24 цагаар |
| 8. Барилга байгууламжийн бүрэлдхүүн | - Уурын зуухны барилга<br>- Түлш хадгалах агуулах<br>- Үнсний зайлуулах талбай<br>- Цэвэр усны хоолой<br>- Цахилгаан хангамж<br>- Дулааны гол шугам хоолойтой холбох дулааны худаг 2ш /барилгаас 5 м зайд/<br>- Бохир ус зайлуулах шугам хоолой<br>- Гадна гэрэлтүүлэг,Нүүрсний агуулахын гэрэлтүүлэг<br>- Хашаа хаалга төлөвлөх |
| 9. Халаалтын зууханд тавигдах шаардлага | MNS 5041:2016 ; MNS 5043:2016 стандартын шаардлага хангасан нам даралтын **НР100Ж** төрлийн зуух эсхүл түүнтэй дүйцэх техникийн үзүүлэлтэй зуух сонгох |
| 10. Барилгын материалын үндсэн бүтээц | Үндсэн хийц бүтээц: Цутгамал төмөр бетон<br>Суурь:Цутгамал<br>Дээвэр: Дээврийн хуйлмал материалаар хамгаалагдсан хавтгай, дээврийн усыг зайлуулах задгай хаялагатай,<br>Хучилт: Төмөр бетон хавтан,<br>Гадна хана: Дотор агаарын температурыг 20° С- с багагүй байлгахад хангалттай тоосгон өрлөг, гал дэмждэггүй, барилгы норм, шаардлага хангасан дулаалга<br>Гадна засал: Сайн чанарын шавардлага хийж гадна заслын будгаар будах<br>Гадна хаалга: Сайн чанарын бүргэд хаалга<br>Дотор хана: Тоосгон өрлөг<br>Дотор засал: Шавардаж, шохойдох<br>Цонх: Сайн чанарын вакум цонх, торон хамгаалалттай<br>Дотор хаалга: Сайн чанарын модон хаалга<br>Шал: Цутгамал төмөр бетоноор хийж будах, цахилгаан тоноглолын өрөөний цутгамал төмөр бетон шал дээр |




**ҮНДЭСЛЭЛ:** "Эрдэнэс-Тавантолой" ХК-ний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоол

**ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА:** Уурхайд шинээр баригдах ажилчдын хотхон, уурхайн захиргааны барилгуудын болон цаашид өсөн нэмэгдэх дулааны хэрэглээг тооцон усан халаалтын тогоо суурилуулах , уурын зуухны барилга барих

**ХҮЧИН ЧАДАЛ:** Халаалтын нийт ачаалал- 0,7 Гкал/ц; Халуун усны нийт ачаалал-0,4 Гкал/ц

**БАЙРШИЛ:** Цогтцэций сум, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ний ажилчдын хотхоноос 800м зайд

**САНХҮҮЖИЛТ: /төг/** 2.400.000.000

**ГҮЙЦЭТГЭГЧ:** Худалдан авах ажиллагаа дуусаагүй

**ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:** 2021 он

**ХҮРЭХ ҮР ДҮН:** Шинээр баригдах Ажилчдын хотхон, Уурхайн захиргааны барилгуудыг дулаан болон хэрэгцээний халуун усаар хангах

## Захиргааны болон хотхоны барилга, гаражийн барилгын гадна шугам сүлжээ

**Тайлбар:** Уурхайд шинээр баригдаж байгаа ажилчдын хотхон, захиргааны барилга, авто гараж зэргийг дулаан хэрэгцээний халуун усаар хангах гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэхээр төлөвлөв.

**Шугам сүлжээний бүрэлдхүүн хэсэг:**

- Гадна дулаан хангамж: Ф38-133мм-ийн хөндлөн огтлолтой, 572,4м урттай цайрдсан ган хоолойг бетон сувагт бетон дэр дээр үл гулсах тулгууртайгаар угсарна.

Гадна усан хангамж, ариутгах татуурга: Усан хангамжийн шугамыг Ф57х3,5мм-ийн голчтой цайрдсан ган хоолойгоор дулааны шугамтай хамт угсарна. Ариутгах татуургын шугамыг өөрийн угсгалаар Ф100-150мм-ийн хөндлөн огтлолтой, 421м урттай хуванцар хоолойгоор хийж гүйцэтгэнэ,

Гадна цахилгаан хангамж: ХТП: 2х260кВт, 10/0,4Кв ЦДКШ: АВВБ-4х185-255мм$^2$ –ийн хөндлөн огтлолтой, 1359,67м урттай, хөнгөн цагаан голтой, хос шугам татаж барилгын оролтын ерөнхий самбаруудыг тэжээнэ

Гадна холбоо, дохиолол: 12 core-ийн 1000,0м урт агаарын кабель, 500,0м урт газрын шилэн кабель татаж барилгад оруулан төгсгөлийн төхөөрөмжинд холбоно





**ҮНДЭСЛЭЛ:** “Эрдэнэс-Тавантолой” ХК-ний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоол

**ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА:** Уурхайд шинээр баригдах ажилчдын хотхон, уурхайн захиргааны барилга болон гаражийн барилгын дулаан, хэрэгцээний халуун хүйтэн усны шугам.

**ХҮЧИН ЧАДАЛ:** Дулаан - 572,4м, ус хангамж - 421м

**БАЙРШИЛ:** Өмнөговь аймгийн Цогтцэций сум. Уурхайн ажилчдын хотхон, 66 га газар

**САНХҮҮЖИЛТ: /төг/** 1.200.000.000

**ГҮЙЦЭТГЭГЧ**: Худалдан авах ажиллагаа дуусаагүй

**ХЭРЭГЖИХ ХУГАЦАА**: 2021 он

**ХҮРЭХ ҮР ДҮН:** Шинээр баригдах Ажилчдын хотхон, Уурхайн захиргааны барилгуудыг дулаан болон хэрэгцээний халуун усаар хангана.